



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/40/

Мөрөн сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 10 дугаар зүйлийн 10.2, 30 дугаар зүйлийн 30.1, 30.4, 39 дүгээр зүйлийн 39.1, 39.3, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2.6, Засгийн газрын 2017 оны “Захиалагчийн дүрэм батлах тухай” 170 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 278 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Байгаль орчноо хамгаалах загасчлах жуулчлалыг хөгжүүлэх төсөл /Хөвсгөл/-ийн хүрээнд нэмэлтээр хэрэгжүүлэх “Сургалт, тоног төхөөрөмжийн тохируулга, зүгшрүүлэх, технологи шийдлийг нутагшуулах, байгаль орчныг хамгаалах” арга хэмжээний зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээн авах, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх чиг үүрэг бүхий захиалагчийн төлөөлөгч, ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч:

П.Мөнхжаргал (Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

Ё.Батсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн бодлого үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн)

М.Батцэцэг (Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хуулийн зөвлөх)

А.Даваадорж (Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:


Д.Даваадорж (Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ан амьтан, биологийн төрөл зүйл, нөхөрлөл хариуцсан мэргэжилтэн)

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Байгаль орчноо хамгаалах загасчлах жуулчлалыг хөгжүүлэх төсөл /Хөвсгөл/-ийн хүрээнд нэмэлтээр хэрэгжүүлэх “Сургалт, тоног төхөөрөмжийн тохируулга, зүгшрүүлэх, технологи шийдлийг нутагшуулах, байгаль орчныг хамгаалах” зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, зөвлөх үйлчилгээг хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах,

гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын үр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч (Б.Оюунтуяа)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ